

“РЕМИКОН”ХК-ИЙН
“ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ”-ИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

Дугаар 21/08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн
хойшлогдсон хурал хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6 заалт, “Ремикон” ХК-ийн 2021 оны 04-р сарын 29-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын”-ийн тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Ремикон” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын ирц хүрээгүй тул хойшлогдсон хурлыг **2021 оны 05 дугаар сарын 26-ны Лхагва гаригт 11.00 цагт** “Ремикон”ХК-ийн үйлдвэрийн байранд танхимаар болон цахимаар буюу зайнаас зарлан хуралдуулсугай.
2. Хойшлогдсон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр өөрчлөхгүй байхаар тогтоосугай.
3. Хойшлогдсон хурал хуралдуулах тухай Хувьцаа Эзэмшигчдэд дахин зарыг 2021 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн дотор дахин хүргүүлсүгэй.
4. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хуралыг зохион байгуулах комиссын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
5. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
6. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар Г.Батхуягийг, гишүүнээр Т.Одмаа нарыг тус тус томилсугай.
7. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд мэдээлэх зарын загварыг *Хавсралт №1*–ээр баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БАТХУЯГ

2021.04.30-ны өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

РЕМИКОН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД



“Ремикон” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын ирц хүрээгүй тул хойшлогдсон хурлыг **2021 оны 05 дугаар сарын 26-ны Лхагва гаригт 11.00 цагт** Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, “Ремикон”ХК-ийн үйлдвэрийн байранд танхимаар болон цахимаар буюу зайнаас зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1.Ремикон ХК-ийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,

2.Ремикон ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөтэй танилцах,

3.Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,

4.Ремикон ХК-иас 2020 оны санхүүгийн жилийн ашгаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,

5.Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

Ремикон ХК-д хувьцаа эзэмшигч ээлжит хурлын материалтай Гаүли ХХК брокер дилерийн компанийн байранд танилцана уу.

РЕМИКОН ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Утас:88881996, 88065253, E-mail: info@remicon.mn

РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021.04.29

№ ХЭХ-21/1/1

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6 заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн
хойшлогдсон хурал хуралдуулах тухай

1. Компаний тухай хуулинд заасан хурлын ирц хүрээгүй тул Ремикон ХК-ийн 2021 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хойшлуулан хуралдуулсугай.
2. Хойшлогдсон хурлын товыг 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Лхагва гаригт 11.00 цагт "Ремикон" ХК-ийн үйлдвэрийн байранд танхимаар болон цахимаар хуралдахаар тогтоосугай.
3. Хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг 2021 оны 5 дугаар сарын 16-ний өдрийн дотор дахин мэдэгдэхийг Ремикон ХК-ийн гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР